

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/10

Арвайхээр

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн 2.1 дэх заалт, 2017 оны 270 дугаар “Хүүхэд хөгжил хамгаалал” үндэсний хөтөлбөрийн 1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Заавар журам батлах тухай” 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 6-23 сартай хүүхдүүдэд дархлаа дэмжих, бичил тэжээлийн дутлаас сэргийлэх зорилгоор олгох олон найрлагат бичил тэжээлийн холимогийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарийн дагуу түгээлт хийн, тайланг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 100 дугаар тушаалийн тавдугаар хавсралтын 1.6 дугаарт зааснаар сар бүр ирүүлэхийг сумын эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М. Золзаяа)-д, мэргэжил арга зүйгээр хангаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

018900030

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 03 дугаар сарын 20-ны
өдрийн 110 дугаар тушаалын
хавсралт



6-23 САРТАЙ ХҮҮХДИЙН ОЛОН НАЙРЛАГАТ
БИЧИЛ ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Сумын эрүүл мэндийн төв	6-23 сартай хүүхдийн олон найрлагат бичил тэжээл	
		Тоо, хэмжээ /хайрцаг 1х30/	Үнийн дүн/төг/
1	Баян-Өндөр	158	673080
2	Бүрд	116	494160
3	Бат-Өлзий	387	1648620
4	ББУ	141	600660
5	Баянгол	150	639000
6	Гучин-Ус	158	673080
7	Өлзийт	108	460080
8	Богд	281	1197060
9	ЗБУ	167	711420
10	Нарийнтээл	153	651780
11	Сант	150	639000
12	Тарагт	140	596400
13	Төгрөг	130	553800
14	Уянга	434	1848840
15	Хайрхандулаан	155	660300
16	Хужирт	285	1214100
17	Нийт	3113	13261380